# СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

# Хүн ам

- 2022 оны жилийн эцэст:

- Өрх-808
- Хүн ам 2308,
- Үүнээс: Эрэгтэй-1280
- Эмэгтэй-1028
- 0-18 насны хүүхэд-671
- +55 дээш - 352

# Мал сүрэг

2022 онд мал сүргийн тоо **327192** мянган толгой буюу **11,5** хувиар өссөн.

Үүнээс : Ямаа- 155519

Хонь-139803

Үхэр-3132

Адуу-13363

Тэмээ-15375

# НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

- **1.1 Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2020 онд 54 хувь байсныг 2024 онд 91%-д хүргэнэ.**

- **Эм эмнэлгийн хэрэгсэлийн бэлэн байдлыг хангах хүрээнд эрүүл мэндийн яамнаас хандив тусламжаар** /нэг удаагийн хлад, компинзон, амны хаалт, үзлэгийн бээлий, нүдний шил, малгай, улавч, ремдисивир 100мг, хормогч, тамифлю/ **зэрэг эм, эмнэлгийн хэрэгсэлээр 100%-тай хангагдсан байна.**
- **Монголын Улаан Загалмайн нийгэмлэгээс PCR оношлуур 100 ширхэгийг хандивлаж эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлсэн.**

# ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1.1 Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлгийг 2020 онд 43% байсныг 2024 он гэхэд 95% хувьд хүргэнэ.

- 2022 онд Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр иргэдэд цахим хэлбэрээр 46 төрлийн 183 мэдээллийг цахим хаягаар дамжуулан 7 сургалтыг 481 иргэнд хүргэсэн.
- “Элэг бүтэн монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Элэгний В, С вирусын илрүүлэх шинжилгээ түргэвчилсэн тестээр үнэ төлбөргүй оношилгоо хийж, 196 хүн хамрагдсанаас элэгний В, С вирустэй 2 иргэн аймгийн халдвартын эмчийн хяналтанд хамрагдсан.

# Эрт илрүүлэг урьдчилсан сэргийлэх үзлэгт:

Иргэдийн эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 2383 хүн хамрагдахаас 1283 хүн хамрагдаж 53,9%-тай байна.






## “Монгол-Япон” эмнэлэгт Байгууллагын багц эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ оношилгоонд 89 төрийн албан хаагчдыг хамруулсан.










# ➢ "Хавдарын эсрэг хамтдаа" хөтөлбөрийн хүрээнд




- "Хавдарын эсрэг хамтдаа" хөтөлбөрийн хүрээнд Артерийн даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 460 хүн хамрагдсан. Умай хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг шинжилгээнд 76 эмэгтэй хамрагдаж 71%-тай байна. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 487 эмэгтэй хамрагдаж 69%-тай байна. Нийт Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 60%-тай байна.

# 2.1.2 Эмнэлэгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

2022 онд Эрүүл мэндийн төв эмнэлгийн үйлчилгээнд **“Цусны шинжилгээ”**-ний аппарат, УВЧ шарлагын аппарат, Гал тогоонд дээжний хөргөгч зэрэг тоног төхөөрмжөөр хангагдаад байна.

- **“Цусны шинжилгээ”-ний аппарат**






**2.1.2 Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.**



Амны хөндийн өвчлөлийн /Шүд цооролтын/ тархалтыг бууруулах зорилгоор ЗОННЕ шүдний эмнэлэгтэй хамтран шүдний суурин бор машины ком тоног төхөөрөмж үзлэгийн багажаар хангагдаж, амны хөндийн урьдчилан сэргийлэх шүдний үзлэгт 360 хүүхэд хамруулсанаас 150 хүүхэд шүдээ эмчлүүлж эрүүлжүүлсэн.

# “Илүүдэл жингүй эртэч монгол” аяны хүрээнд:

2022.02.28-06.01-ний хооронд “Илүүдэл жингүй эртэч монгол” аянд 74 иргэн хамрагдаж хийн дасгал, йог, хөгжимт дасгал, дугуйн спорт, алхалт дасгал хөдөлгөөнд ахмадуудыг уриалан нэгдүүлж идэвхжүүлэв.





## 2.2. Биеийн тамир, спорт-Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагсдыг 5 хувиар нэмэгдүүлж А, В үнэлгээтэй иргэд 2020 онд 30 хувьтай байсныг 2024 онд 86 хувьд хүргэнэ.

- **“ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аянд**

Монгол Улсын Ерөнхий Сайдын санаачилгаар зохион байгуулагдсан “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ” аянд 2022 оны 2-р сарын 28-наас 06 сарын 01-ны өдөр хүртэл хэрэгжүүлж, байгууллага хамт олон иргэдийн оролцоог нэмэгдүүлж 80 гаруй иргэд Өглөөний дасгалд хамрагдаж энэ хугацаанд биеийн тамир дасгал хөдөлгөөнийг дэмжих спортын тэмцээн уралдаан-7, бүжгийн тэмцээн-1ийг тус тус зохион байгууллаа.








## 2.3.2 СӨБ-ийн хамран сургалтыг 41%-д ЕБС-ийн бага суурь боловсролын хамран сургалт 2024 онд 70%-д хүргэж боловсролын салбарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

**СӨБ-ийн хамран сургалтыг 41%-д ЕБС-ийн бага суурь боловсролын хамран сургалт 2024 онд 70%-д хүргэж боловсролын салбарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.**

- СӨБ-д хамран сургалт танхимаар- 51.6%, хувилбарт-19.4%, зайны сургалтаар-1.6% байна. ЕБС-д бага суурь боловсорлын хамран сургалт 100%, тойргийн сургуульд 49.1% бусад тойргийн сургуульд 50.8%-тай байна
- **"Багшийн хөгжлийн төв"-**ийн тохижилт ая тухтай орчин бүрдсэн. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургууль бүрд олгогдсон УХААЛАГ САМБАР, Өнгөт принтерийг хүлээн авч багш нарын тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүллээ.
- Сайдын А/170 дугаар тушаалын дагуу багш нар улсын төсвийн дата багц, яамны интернетээр бүрэн хангагдан ажиллаж байна.
- Хүүхдийн тав тухтай орчинг сайжруулахаар 2023 онд сургуулийн дотуур байр 580.000.000 төгрөгний өртөг бүхий их засварт орохоор зураг төсөв нь батлагдсан.

# 2.3 . Боловсрол-Сургалтын чанарын үнэлгээний дундажийг 2020 онд 57 хувь байсныг 2024 онд 93 хувьд хүргэнэ.

2.3 . **Боловсрол-Сургалтын чанарын үнэлгээний дундажийг 2020 онд 57 хувь байсныг 2024 онд 93 хувьд хүргэнэ.**

БШУС-ын А/500 дугаар тушаалын дагуу Улсын хэмжээний 660-н сургуулийн 214-т шалгарч 4-р шатанд үнэлэгдсэн. Сургууль цэцэрлэгийн 2021-2024-ийг хэрэгжүүлэх "Багшийн хөгжлийн хөтөлбөр" "Чадварлаг багш хөтөлбөр"-ийн хүрээнд "Хүүхэд нэг бүрээ хөгжүүлдэг багш" багш нарын багшлах арга зүйг хөгжүүлэх сурлагын чанарыг сайжруулах зорилгоор Зөвлөх багш Ч.Нямаа, Ё.Лхагвацэрэн нарын сургалт арга зүйн зөвөлгөөн нь үнэтэй хувь нэмэр болсон.





# “Их соёл-Эх үндэс” хөтөлбөр хүрээнд:

ЕБСургуульд “Их соёл эх үндэс” хөтөлбөрийн хүрээнд 58 сая төгрөгийн өртөг бүхий хөгжим тоног төхөөрөмжөөр хангагдсан.

# Сумын боловсролыг дэмжих дэд хөтөлбөр:

Ирээдүйн инженер “Юнимат төсөл”-ийг хэрэгжүүлж технологийн танхимд сургалтын багаж хэрэглэгдэхүүнийг 14 сая төгрөгөөр санхүүжүүлж багш, сурагчдын оюуны хөрөнгө оруулалт хийсэн.

Сумын ИТХ, Засаг даргын нэрэмжит шалгалтыг зохион байгуулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

## 2.4.4 Хүүхэд залуучууд, гэр бүлийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшилд анхаарч авъяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг сайжруулна.

**”Миний нутгийн гайхамшиг” эко аялал**

- Сумын боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 500л шатахууныг зарцуулан ”Миний нутгийн гайхамшиг” эко аялалыг сургуулийн 1-9р ангийн нийт 170 хүүхдийг хамруулан зохион байгуулж "Өөш манхан" үзэсгэлэнт газарт хичээл орж сургалтын үйл ажиллагаа танхимын бусаар орсон.

## 2.4.4 Хүүхэд залуучууд, гэр бүлийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшилд анхаарч авъяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг сайжруулна.

**Байгаль орчин аялал жуулчлалын газраас зохион байгуулсан аймгийн эко клубуудын 3 дахь удаагийн БҮТЭЭЕ, ХАМГААЛЪЯ чуулган**

- СОУЗ, Лидер аврагч, Өсвөрийн сэргийлэгч, Эко клуб, Донж клуб гэсэн 5 клуб үйл ажиллагаа явуулж байна.
- Байгаль орчин аялал жуулчлалын газраас зохион байгуулсан аймгийн эко клубуудын 3 дахь удаагийн “БҮТЭЭЕ, ХАМГААЛЪЯ” чуулганд Засаг даргын нөөцөөс 176000 төгрөгийн дэмжлэг аван 1 багш, 5 сурагчийн хамт амжилттай оролцлоо.



## 2.4.4 Хүүхэд залуучууд, гэр бүлийн эрхийг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшилд анхаарч авъяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцлийг сайжруулна.

**Сумын Хамтарсан багийн "Гэр бүлийн хүчирхийллийн илрүүлэх механизмыг сайжруулах нь" төслийн хүрээнд**

- "Гэр бүлийн хүчирхийллийн илрүүлэх механизмыг сайжруулах нь" төслийн хүрээнд "Архигүй амьдралын зөвлөх" доктор Цогтсугирыг урьж Тархины лекц сургалтад 40 гаруй иргэдийг хамруулсан. Мөн архины хамаарал бүхий 10 гэр бүлийг вакумжуулсан сургалтад хамруулах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулснаар 3 иргэн хорт зуршил архинаас татгалзсан.

# ТАРХИНЫ ЛЕКЦ СУРГАЛТ:

Гэр бүлийн хүчирхийллийн илрүүлэх механизмыг сайжруулах нь” 5,0$ өртөгтэй төслийг 2020-2022 онд хэрэгжүүлж “Архигүй амьдралын зөвлөх” доктор Цогтсугирыг урьж Тархины лекц сургалтад архины хамаарал бүхий 10 гэр бүлийг вакумжуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулснаар 3 иргэн хорт зуршил архинаас татгалзсан.






## 2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал-Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай орлоготой байх нөхцлийг бүр

**Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн иргэний байнгын ажлын байрыг 2020 онд 56% байсныг 2024 онд 100%-д хүргэнэ.**

- Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрийн “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт” 310 ба түүнээс доош оноотой өрхийн 1 иргэн “Оролцоо” төсөлд хамрагдсан. Түр ажлын байраар 33-н иргэн /мод тарих услах, хог цэвэрлэх/ хамрагдсан. 14 иргэн байнгын ажлын байртай болсон.

## 2.4.2 2020 онд нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар 60 хувь байсныг 2024 онд 100 хувь нэмэгдүүлнэ.

**Нийгмийн халамжийн үйлчилгээ авдаг 300 гаран иргэн байдаг**




Үүнээс: Тэтгэвэр-31 иргэн, Асаргаа-41 иргэн, АДМТ- 46 иргэн, Цалинтай эх - 96 иргэн, Жирэмсэн эхийн тэтгэмж-19 иргэн бүгд 100% цахим карттай.

Нийгмийн халамжийн үйлчилгээг 80% цахимаар хүсэлт гаргах боломжтой. Иргэдийг цахимаар хүсэлтийг гаргаж хэвших тал дээр ажиллаж байна

# 2.5 Үндэсний бахархал, өв соёл

**Иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа 2019 онд 45% байсныг 2024 онд 93.6%-д хүргэнэ.**

- ТСҮХД-т 26 газрын 109-н дурсгалт газруудыг хамгаалалтанд авч тухайн нутгийн 14-н малчин иргэнтэй гэрээ байгуулсан







- Хөдөөгийн багуудад явуулын номын сангийн үйлчилгээг 4 удаа зохион байгуулсан.
- Үндэсний бичиг соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор - МУАЖ.Н.Дагийранзын "Уулган шар" Данзанравжаагийн "Үлэмжийн чанар бүтээлүүдийг уйгаржин монгол бичгээр бичүүлж олон нийтэд сурталчилж мөн СББӨ-ийг өвлөн уламжлагч зураач, уран бичигтэн Ц.Бямбажавын уран бүтээлийг цахимаар сурталчилж нийт 944 иргэнд хүртээн ажилласан.

# ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

**Эдийн засгийн бодлого**

Малчид малын гаралтай сүү цагаан идээгээ тогтмол боловсруулж зах зээлд нийлүүлэхийн зэрэгцээ уламжлал болгон зохион байгуулагддаг үзэсгэлэнд тогтмол оролцож ирсэн. Тухайлбал "Дундговь Түншлэл-2022" үзэсгэлэн худалдаанд 5-р багийн малчин Д.Бямба цагаан идээгээр оролцож "Ямааны ааруул"-аар аймгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарсан. Цаашлаад нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхээр зорьж байна. 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангаас “Буянбулаг өрнөх хоршоо” нь эсгий үйлвдэрлэлийн цехийн үйл ажиллагааг өргөтгөх, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхээр 50 сая төгрөгийн зээлийг олгосон. Зээл олгосоноор шинээр байнгын ажлын байр-2, түр ажлын байр -2 бий болсон.






# 3.2 Санхүү, төсвийн зохицуулалт

- **Санхүү, төсвийн зохицуулалт**

Орон нутгийн төсвийн орлого 100-115 хувиар биелж, төсвийн өр авлагагүй ажиллаж байна

## Зорилт: Уул уурхайн хайгуул ашиглалтын лицензтэй аж ахуй нэгжүүдэд хяналт тавих тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс орох орлого 2020 онд 30% байгааг 2024 онд 60 хувьд хүргэнэ

**Уул уурхайн хайгуул ашиглалтын лицензтэй аж ахуй нэгжүүдэд хяналт тавих тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс орох орлого 2020 онд 30% байгааг 2024 онд 60 хувьд хүргэнэ.**

2022 онд Уул уурхайн хайгуул ашиглалтын лицензтэй аж ахуй нэгжүүдээс нөхөн сэргээлтийн барьцааны орлого 15.995.000 төгрөг орсон. 105.9 сая төгрөгийг нөхөн сэргээлтэд өгч Нөхөн сэргээлт хийгдсэн.

# 3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

## Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

- 2022 оны байдлаар аюулгүй нөөц өвс-120тн, тэжээл-5тн үлдэгдэлтэй байна. Энэ жилийн хувьд зуншлага тааруу байсан хэдий ч малчин өрх бүр өөрсдийн нөөц боломжоороо гар тэжээл бэлтгэж өнөөдрийн байдлаар 52,1тн, хужир-2,1тн бэлтгээд байна.
- Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд өвсний хямд үнийн бодлого барьж ажиллаж байна.







# 3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр

- **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр**

- 2022 оны байдлаар аюулгүй нөөц өвс-58,5тн, тэжээл-5тн үлдэгдэлтэй байна. Энэ жилийн хувьд зуншлага тааруу байсан хэдий ч малчин өрх бүр өөрсдийн нөөц боломжоороо гар тэжээл бэлтгэж өнөөдрийн байдлаар 52,1тн, хужир-2,1тн бэлтгээд байна.
- Малчид үйлдвэрийн аргаар бус уламжлалт аргаар махыг борлуулж байна. 2022 оны 11-р сарын байдлаар 1712,6тн махыг зах зээлд борлуулсан байна.
- Дэл уулын улаан ямааны  ноолуурын гарц ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 3, 4, 5-р багийн 8 өрхийн 40 гаруй ямаанд хэмжилт хийж, ноолуураас дээж авч шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний хариу шинжлэх ухааны үндэслэлтэй гарч 2023 оны хавраас судалгааны ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.





# 3.4 Аялал жуулчлал

**Аялал жуулчлал**

- Өлзийт сумын газар нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг 4 жуулчны бааз, 2 элсны сувилал, 3 гэр бааз үйл ажиллагаа явуулж байна.
- Сумын нутагт байрлах “Цагаан суварга”-т 2022 оны 7 дугаар сард “Сэтгэшгүй оддын чуулган” арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан.



# 6.1.1.7 Хог ачих, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцлагажуулж, тогтмолжуулна.

**6.1.1.7 Хог ачих, тээвэрлэх үйл ажиллагааг хариуцлагажуулж, тогтмолжуулна.**

- 2022 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3 тн даацтай Кама маркын автомашиныг 39 сая төгрөгөөр авч сар бүрийн 25-30 хооронд хог ачиж байна.





## Зорилт 6.1.2. Сумын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангаж санал авсан иргэдийн тоо 2020 онд 70% байсныг 2024 онд 97 %-д хүргэнэ.

**Сумын ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ**

- 2022 онд нийт-965.133.100 төгрөгний өртөг бүхий 26-н ажлыг хийж хэрэгжүүлэхээс 700.000.000 төгрөгний 23-н ажил нь хийгдсэн байна. Үлдсэн 3-н ажил нь 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.
- Хэрэгжилт 88.4%

# 3.4 Аялал жуулчлал

**“Цагаан суварга” байгалийн үзэсгэлэнт газарт “Отоглох цэг” байгууллаа.**

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 100 сая төгрөгний санхүүжилтээр Дундговь аймгийн Өлзийт сумын “Цагаан суварга” байгалийн үзэсгэлэнт газарт “Отоглох цэг” байгууллаа.








# ДӨРӨВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

## 4.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ

- **Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 60 хувьтай байгааг 2024 онд 93 хувьтай болгож нэмэгдүүлнэ.**

- "Хүний хөгжил зерэг хандлага, иргэний оролцоо" малчдын зөвлөгөөн зохион байгуулж 260 малчин оролцлоо. Зөвлөгөөнд төрийн байгууллагууд ажил үйлчилгээ, шинээр гарч байгаа хууль дүрэм, журмын талаар "Бодит мэдээлэл иргэний оролцоо" номыг бэлтгэн хэвлүүлж сумын 650 гаруй өрхөд түгээж сургалт, сурталчилгаа хууль, эрх зүйн туслалцаа үзүүлсэн байна.
- Шилэн кабельд холбогдсоноор Аймгийн шуурхай мэдээллийг интернетээр хүлээн авах Цахим хурлын тоног төхөөрөмжөөр хангагдсан.

# 4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба

- **Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 61 хувь байсныг 2024 онд 89.5 хувь бууруулна**

- Төрийн байгууллагуудын 98 төрийн хаагчтай Ёс зүйн гэрээг байгуулан ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагч-5, удирдах ажилтны сул орон тоо-1 байгаа энэхүү ажлын байрны захиалгыг тухай бүрд нь ТАСЗөвлөлд хүргүүлж ажиллаж байна.
- "Ёс зүйтэй, хариуцлагатай, бүтээлч төрийн албан хаагч" зөвлөгөөний үеэр Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг өгч, тэнцсэн 2 албан хаагч ТАНГАРАГ өргөж Төрийн жинхэнэ албан хаагч болсон





# Ёс зүйтэй, хариуцлагатай, бүтээлч төрийн албан хаагч” зөвлөгөөн

Аймгаас зарласан “Хандлагаа өөрчилж-Хамтдаа хөгжье” аянд нэгдэж сумын “Ёс зүйтэй, хариуцлагатай, бүтээлч төрийн албан хаагч” зөвлөгөөнд 113 албан хаагч оролцов. Аяны хүрээнд: Подкаст ярилцлага-1, Харилцаа хандлага өөрчлөх ТАХ-ийн сургалт, ТАХ-ын дунд хуулийн видео бичлэг, ажлын байрны дасгал, спортын 3 төрөлт тэмцээн зохион байгуулж шилдэг албан хаагч, хамт олныг тодруулж  урамшуулсан.







## 4.3.1. Гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг барагдуулах бодит нөхцлийг дээшлүүлж, 2019 онд 53 хувьтай байгааг 2024 онд 87

**Аймгийн ГХУСАЗЗ-өөс “Авлигад үгүй гэж хэлье”, “Зөвийг зөвлөе”, “Хүүхдийн эрх”, “Байгалиа хамгаалъя”, “Илрүүлье” “Хамтарсан багаараа хамгаалъя” нэгдсэн аян арга хэмжээнүүдийн хүрээнд нээлттэй өдөрлөг зохион байгууллаа**

- Аймгийн ГХУСАЗЗ-өөс “Авлигад үгүй гэж хэлье”, “Зөвийг зөвлөе”, “Хүүхдийн эрх”, “Байгалиа хамгаалъя”, “Илрүүлье” “Хамтарсан багаараа хамгаалъя” нэгдсэн аян арга хэмжээнүүдийн хүрээнд нээлттэй өдөрлөг зохион байгуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэргэжлийн сургагч багш нар сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 6 багийн 350 иргэн оролцсон.

## Зорилт 4.3.2. Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 50 хувьтай байсныг 2024 онд 100% хувьд хүргүүлнэ.

**Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлж, гэмт хэргийн илрүүлэлт 2020 онд 50 хувьтай байсныг 2024 онд 100% хувьд хүргэнэ.**

- Иргэдийн аюулгүй байдалыг хангах, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ЗДТГ, Шатахуун түгээх станц нь гадна дотно тал "МБЦДС" ХХК, "ДДБГА" ХХК нь гадна, дотор талын орчноо камержуулсан. Яамны хөрөнгө оруулалтаар Сургууль, цэцэрлэг нь гадна орчинд 9 сая төгрөгийн өртөг бүхий 26 ширхэг камерыг суурилуулж хяналт тавин ажиллаж байна.

# Засмал замын гэрэлтүүлэгийн засвар үйлчилгээ:

Засмал зам дагуух нийт 50 ширхэг гэрэлтүүлгээс 23 ширхэг гэрлийг шинээр сольж засварласан.






# Гамшгийн бэлэн байдлын дадлага сургууль:

Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний Гамшгийн эрсдэлийг бууруулах, чадавхжуулах танхимын болон хээрийн дадлага сургууль зохион байгуулж 66 алба хаагч, 13 тээврийн хэрэгсэл, багаж зэвсэглэмжтэй оролцож хангалттай үнэлгээ авсан.









## 2022 оны ОНХС “Гамшгийн бэлэн байдлын бэлтгэх” хамгаалах хувцас, хэрэгсэл 20 сая төгрөгийн өртөг















| д/д | Аврах багаж хэрэгсэл, техникийн нэр | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Анхны тусламжийн иж бүрдэл үүргэвч | 66ш | 50.000 | 3.300.000 | |
| 2 | Үүргэвч | 66ш | 35.000 | 2.310.000 | |
| 3 | Эрээн хувцас (3 хос бүрдэл) | 66ш | 150.000 | 9.900.000 | |
| 4 | Станц | 10ш | 68.000 | 680.000 | |
| 5 | Дува | 6ш | 32.000 | 192.000 | |
| 6 | Цэргийн Майхан | 3ш | 900,000 | 3,600,000 | |
| | **Дүн** | | **19.982.000** | | |

# “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговио ногооруулъя” мод тарих аяны хүрээнд:

Хаврын ээлжний мод тариалалтаар иргэд айл өрх 300 мод, ААН байгууллага 1250 модыг шинээр тарьлаа.

Намрын ээлжийн мод тарилалтаар шинээр 1 ногоон байгууламж бий болгож 1 га талбайд 1000 мод тарьж хашаажуулсан. Мод тооллогоор нийт 7206 мод тоологдсон.









# ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ДЭД БҮТЭЦ

**Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил**

- "Цагаан суврага" "Буянт багийн төв"-үүдэд үүрэн холбооны оператор "Юнител" корпорац өөрийн сүлжээгээ шинээр суурилуулж 200 гаруй малчин өрх цахим сүлжээгээр хангагдаад байна.

# Шинэ хөдөө төслөөр "Цагаан суврага", Буянт багт юнитейлийн сүлжээ суурилуулав.





# “Хүний хөгжил зерэг хандлага, иргэний оролцоо” малчдын зөвлөгөөн

Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн зорилтыг хэрэгжүүлж “Хүний хөгжил эерэг хандлага, иргэний оролцоо” малчдын зөвлөгөөнд 260 гаруй малчид оролцлоо.

“Бодит мэдээлэл иргэний оролцоо” номыг бэлтгэж өрхийн тоогоор түгээсэн.








# Төвийн бүсийн “Мандалын хурд-2022” хурдан морины уралдаан

“Мандалын хурд-2022” уралдаанд 3 насны хурдан морьд уралдсан.





# Малчдад зориулсан сургалтаар

Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны малын үржил селекцын сургалт, малын халдварт өвчний талаар, улаан загалмайн анхан шатны тусламжийн сургалтыг 6 багийн 250 гаруй малчдад зохион байгуулсан.





# Аймгийн “ИРГЭДИЙН СПОРТ ЫН НААДАМД

2022 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион байгуулагдсан "ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМ"-д шагайн харваа, эрэгтэй волейбол, эрэгтэй сагсан бөмбөг, эрэгтэй шатар зэрэг 4 төрлөөр оролцсон баг тамирчдын байр, хоол, унаа, мандатны төлбөрийг бүрэн хариуцсан.









# Зүүн бүсийн Төрийн албан хаагчдын зөвлөгөөн 2022.09-08-09

“Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 140 гаруй албан хаагчид оролцсон.









# “Нутгийн дуудлага хүндэтгэлийн чуулга” уулзалт

2022 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улаанбаатар хотноо “Нутгийн чинь дуудлага хүндэтгэлийн чуулга” уулзалтыг зохион байгуулж нутгийн уугуул урлаг соёлын алдартнууд болон залуу уран бүтээлчид 300 гаруй иргэд оролцов.





# Хүмүүнлэгийн сайн үйлсийн аяны хүрээнд: 4 иргэнд 5 ханатай өргөө цагаан гэр гардуулж нийгмийн баталгааг хангав.










# АНХААРАЛ ТАВЬСАН ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА.